



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 6/04

Өмнөдэлгэр сум

С.Очирыг ажилд түр томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1, 49.1, 49.2 дахь хэсэг, 50.1.5.дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатарын Очирыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хөгжмийн багшаар ажиллуулсугай.

2.С.Очирын албан тушаалын зэрэглэлийг ТҮСБ-3 буюу 1,414,000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга) төгрөг, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцон бодож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3. С.Очирыг албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА



Т.МӨНХТӨР